



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 578

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө олж авах зөвшөөрөл  
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.3, 3.4 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бodoх бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ын 4.4, 5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Консерваторийн албан хэрэгцээнд зориулан 35,000,000.00 (гучин дөрвөн сая нэг зуун) төгрөгт багтаан 1 ширхэг автомашин олж авахыг зөвшөөрч, худалдан авах автомашины төхникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Монгол Улсын Консерваторийн захирлын үүрэг гүйцэтгэгэй Ц.Пүрэвхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

3.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

0001099



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн  
578..... дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсын Консерваторийн худалдан авах автомашины техникийн  
үзүүлэлт, үнийн дээд хязгаар

Д/д	Автомашины техникийн үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Худалдан авах үнийн дээд хязгаар
				(төгрөг)
1	Суудлын тоо 5, хөдөлгүүрийн багтаамж 2500 cc хүртэл /улсын дугаар аваагүй/	ш	1	35,000,000.00
<b>Нийт дүн</b>			<b>1</b>	<b>35,000,000.00</b> <b>(гучин таван сая)</b>